

**ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН АЛБАНЫ БҮТЭЦ БҮРЭЛДЭХҮҮН,  
ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ТЕХНИКИЙН ШААРДЛАГА**

№

2024 оны 04-р сарын 10-ны өдөр

Ажлын нэр терөл	Тайлбар
Ажил гүйцэтгэх үндэслэл	Захиалагч байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа объектуудын хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг бүрэн бүтэн хангах.
Захиалагч байгууллага	“ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК
Байршил	“Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн Дундговь аймгийн Гурвансайхан сум, Чулуут багийн нутагт орших Салхит уулын баяжуулах үйлдвэр
Гэрээт ажлын зорилго, үр дүн	<b>Зорилго:</b> Хамгаалалтын алба нь байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа объектуудын хэвийн үйл ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор гаднын гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэрэг, зөрчил, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, обьектод заавал биелүүлэх дотоод дүрэм журмыг дагаж мөрдүүлэхэд чиглэсэн мэргэжлийн цогц үйлчилгээ үзүүлэх.
Гүйцэтгэх ажил	<ol style="list-style-type: none"> <li>1. Салхит уулын баяжуулах үйлдвэр /Цаашид СУБУ/-ийн шалган нэвтрүүлэх пост 1, 3, 5, 6 /Цаашид ШНП/-уудад байнгын буюу хоногийн 24 цагийн турш хамгаалагч ажиллуулах.</li> <li>2. СУБУ-ийн ШНП-оор нэвтрэх бүх хөдөлгөөн СУБУ-ийн бүсэд нэвтрэх журмын дагуу зөвшөөрөлтэй байх тул зөвшөөрлийн хуудасгүй хөдөлгөөнийг ШНП-оор нэвтрүүлэхгүй байх.</li> <li>3. СУБУ-ийн ШНП-оор нэвтрэх иргэн, зочин, ажилтны ажлын болон иргэний үнэмлэхийг холбогдох зөвшөөрлийн хуудсан дээрх мэдээлэлтэй тулгаж таарсан тохиолдолд холбогдох журмын дагуу үзлэг шалгалт хийж ШНП-оор нэвтэрүүлнэ.</li> <li>4. СУБУ-ийн бүсэд нэвтрэх журмын дагуу шаардлага хангасан тээврийг хэрэгсэл, ачаа бараа, сэлбэг хэрэгсэлд үзлэг шалгалт хийж нэвтрүүлнэ.</li> <li>5. СУБУ-ийн бүс доторх эд хөрөнгө болон бүх объектууд, хашаа, ногоон байгууламж, СУБУ-ийн бүсийн гаднах худаг усан сангийн байруудын бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавина.</li> <li>6. Хөдөлгөөнт эргүүл ажиллуулах /3 цаг тутам СУБУ-ийн дотор гаднах бүх объектуудад хяналт тавьж тэмдэглэл хөтлөх/</li> <li>7. СУБУ-ийн үйлдвэрийн захирал, ахлах инженер, ХАБГГАХ инженер, ХАБЭА-н ажилтанд харуул хамгаалалтын компани өөрийн хийж гүйцэтгэж байгаа ажлын мэдээг тогтмол мэдэгдэж байх. /дотоод мэдээлэл солилцооны групп ажиллуулах/</li> <li>8. Хийж гүйцэтгэж байгаа ажилтай холбоотой зөрчил дутагдал илэрсэн даруйд СУБУ-ийн үйлдвэрийн захирал, ахлах инженер, ХАБГГАХ инженер, ХАБЭА-н ажилтанд мэдэгдэж шаардлагатай хариу арга хэмжээг нэн дариу авах.</li> </ol>

<p><b>Гүйцэтгэх ажил</b></p>	<p>9. Баяжмал ачилтад бэлдэж үйлдвэрээс гаргаж хураасан баяжмалын мэдээллийг баяжмалын няраваас авч тээврийн хэрэгсэлд ачигдаж СУБУ-ийн бүсээс гарах хүртэл тогтмол хяналт тавьж ажиллана.</p> <p>10. СУБУ-ийн ШНП-уудын хөдөлгөөн, хөдөлгөөнт эргүүлийн тэмдэглэлийг цахим болон цаасан хэлбэрээр байнга хадгалах.</p> <p>11. Тухайн өдрийн ШНП-уудын хөдөлгөөн, хөдөлгөөнт эргүүлийн тэмдэглэлийг 2 хувь үйлдэж “ЭАР” ХХК-ийн ХАБГГАХ инженер, ХАБЭА-н ажилтнаар хянуулж, СУБУ-ийн ахлах инженерээр батлуулж 1 хувийг СУБУ-ийн бичиг хэрэгт өгнө, үлдсэн хувийг тухайн харуул хамгаалатын компани архивлах.</p> <p>12. СУБУ-ийн бүс доторх агуулах, болон холбоотой эд хөрөнгүүдийг нэг бүрчлэн хүлээж авч хамгаална.</p> <p>13. Хүлээж авч хамгаалаж байгаа эд хөрөнгийн хашаа, контейнер, агуулахад нэвтрэх зөвшөөрлийг хүлээлгэж өгсөн эзэнтэй хамтран үйлдэж эд хөрөнгийн хөдөлгөөнийг нэг бүрчлэн тодорхой бүртгэж мэдээллийг цахим болон цаасаар хадгална. Хүлээж авч хамгаалаж байгаа эд хөрөнгөөс дутсан тохиолдолд харуул хамгаалалтын компани хариуцна.</p> <p>14. ШНП болон харуулын байрнуудын урсгал засвар арчилгаа үйлчилгээг харуул хамгаалалтын компани хариуцаж ажиллана.</p>
<p><b>Ажиллах хүч, хүний нөөц</b></p>	<p>Өдөр шөнийн ээлжинд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Бүлгийн дарга-1,</li> <li>➤ Диспетчер-2,</li> <li>➤ Ээлжийн ахлах- 4,</li> <li>➤ Хамгаалагч-21,</li> <li>➤ Нийт хүний тоо- 28</li> </ul> <p><b>Тавигдах шаардлага</b></p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Удирдах болон ахлах ажилтнууд нь тухайн албан тушаалд 3-аас доошгүй жилийн ажлын туршлагатай байх;</li> <li>➤ Ээлжийн ахлахууд нь галт зэвсэг ашиглах тусгай зөвшөөрөлтэй байх.</li> <li>➤ Диспетчер нь баримт бичиг боловсруулах чадвартай байх.</li> <li>➤ Хамгаалагч нь харуул хамгаалалтын чиглэлээр 1 болон түүнээс дээш жилийн туршлагатай байх;</li> <li>➤ Хамгаалагч нар тусгай сургалтад хамтрагдаж гэрчилгээ авсан байх.</li> <li>➤ Харуул хамгаалалтын алба хаагчийг шаардлага хангасан ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах;</li> </ul>
<p><b>Тавигдах шаардлага</b></p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Харуул хамгаалалтын үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөлтэй, зөвшөөрөл нь хүчинтэй байх.</li> <li>2. Галт зэвсэг ашиглах тусгай зөвшөөрөлтэй байх.</li> <li>3. Бүх ажилтнууд нь тухайн байгууллагад 1-ээс доошгүй жил ажилласан байх.</li> <li>4. Харуулын пост бүрт гар станц ажиллуулах.</li> <li>5. Бүлгийн дарга, ээлжийн ахлах бүр тусдаа гар станцтай байх.</li> </ol>

6. Өөрсдийн дотоод сүлжээнд холбогдох гар станцыг “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн СУБҮ-ийн ахлах, ХАБГГАХ инженер, ХАБЭА-н ажилтанд тус тусад нь өгөх.
7. Харуул хамгаалалттай холбогдох асуудлаар өөрийн ажилтан болон харуул хамгаалалтын алба хаагчид хууль ёсны шаардлага тавих;
8. Харуул хамгаалалтын үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн тохиолдолд хэрэгжүүлсэн тохиолдлыг холбогдох ажилтнуудаас санал бодлыг авах, гэрээнд заасны дагуу хариуцлага тооцох;
9. Харуул хамгаалалтын алба гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавих ба сар, улирал, жилээр тайланг танилцуулан ажиллах;
10. Харуул хамгаалалтын алба нь орон нутагт ажиллах өөрийн эзэмшлийн тусгай тоноглолтой бартаат зам туулах чадвар сайтай автомашин 1-ээс доошгүй, харуул хамгаалалтын ажилчдыг зөөвөрлөх бартаат зам туулах чадвартай бага оврын автобус 1-ээс доошгүй байх ба компанийн уурхайн бүсэд замын хөдөлгөөнийг зохицуулах, өөрчлөх журмын ерөнхий шаардлагыг хангаж ажиллах;
  - 10.1. Бага оврын суудлын автомашин нь зөв талдаа жолооны хүрдтэй, үзэгдэх байдлыг сайжруулах зорилгоор цагаан өнгөтэй, дөрвөн дугуйндаа хөтлөгчтэй байх;
  - 10.2. Стандартын шаардлага хангасан өндрийн тугтай байна. Нийт өндөр 4 м-ээс багагүй байна. Дарцаг нь 40\*40 см-ээс багагүй хэмжээтэй, амархан нугарч унжихгүй, хатуу материалаар хийгдсэн, гэрэл ойлгогч тууз бүхий тод шар, улбар шар, улаан өнгөтэй байх;
  - 10.3. Тээврийн хэрэгслийн бүх талаас ил харагдах газар байрлуулсан маяктай байна. Маяк нь линзний диаметрээрээ 12 см-ээс багагүй, өндөр нь 15 см-ээс багагүй, гэрэлтэх чадвар нь хангалттай тод байх;
  - 10.4. Радио станцаар тоноглогдсон байх;
11. Радио давтамж ашиглах эрхийн зөвшөөрөлтэй байх ба нотариатаар баталгаажуулсан хуулбар хавсаргах;
12. Уурхайн бүс дэх нийт камеруудын хэвийн болон хэвийн бус ажиллагааны талаарх мэдээллүүдийг холбогдох албан тушаалтан болон удирдах ажилтанд нэн даруй мэдэгдэх;

	<p>13. Үндсэн компанийн эд хөрөнгийг хариуцан ажиллаж буй тохиолдолд өдөр тутмын цэвэрлээг үйлчилгээг тогтмол хийж, ашиглалтын улмаас эвдэрсэн, хагарсан тохиолдлуудад нөхөн засварлах үйлчилгээг яаралтай хийж гүйцэтгэнэ;</p> <p>14. Уурхайн бүс доторх эд хөрөнгө, объектуудын лац ломбогүй, хариуцан ажиллаж байгаа ажилтнуудын санаатай болон санаандгүй үйлдлээс зөрчлүүд илэрвэл рапортод бүртгэж, албан шаардлагыг нэн даруй хүргүүлэн учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллана;</p> <p>15. Эд хөрөнгө, тоног төхөөрөмжүүд, сэлбэг хэрэгслүүдэд бусад материалуудад, зэс голчтой кабелиудыг нарийвчилсан бүртгэлийг тогтмол хийж, эцсийн бүтээгдэхүүн мөнгөний баяжмалуудын нарийвчилсан тоо ширхгийг бүртгэлийн мэдээллийг санхүүгийн нягтлан, нярвууд, уурхайн ахлахуудад хүргүүлэн ажиллах ба харуул хамгаалалтын алба хаагчийн рапортод тогтмол тэмдэглэл хөтлөн ажиллах;</p> <p>16. Харуул хамгаалалтын алба хаагч нарыг 14 хоногт 1 удаа сургалтад дотооддоо хамруулсан байх ба уурхайн бүсэд дэх нийт орох, гарах хүн ба техникийн хөдөлгөөний 7 хоногийн хугацаанд зөрчил, аюултай нөхцөл байдлын талаар шуурхай хурлыг тогтмол гүйцэтгэх хяналтуудыг сайжруулах арга хэмжээг авч ажиллах;</p> <p>17. Харуул хамгаалалтын хариуцлагагүй, сэрэмжгүй байдлаас өдөр болон шөнийн цагаар уурхайн бүсээс болон объектоос эд хөрөнгө, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл бусад материалууд алдагдах, хохирол учирсан, бүртгэлтэй ба бүртгэлгүй кабелиудын алдагдахад холбогдогч эзэн тодорхойгүй зөрчил илэрсэн, хулгайн хийх нөхцөлүүдийг арилгаагүй, арга хэмжээ аваагүй, тухайн аюултай нөхцөл байдлыг албан шаардлагын хүрээнд зөрчлүүдийг арилгуулаагүй, хариу арга хэмжээг авч ажиллаагүй тохиолдолд харуул хамгаалалтын алба хариуцлагаа өөрсдөө хариуцан ажиллах;</p> <p>18. Харуул хамгаалалтын алба хаагч тусгай хэрэгслийг албан үүрэг гүйцэтгэхдээ биедээ авч явах, ажлын байранд унтах, объектоо орхих, согтууруулах ундааны зүйл хэрэглэх, зэвсэг, хэрэгслээ бусдад шилжүүлэхийг хориглох;</p>
<b>Ажлыг гүйцэтгэх хугацаа</b>	<b>ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНД</b>